

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 10

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1					
Хэсгийн дундаж: 100 хувь					
1. Засгийн газрын тогтоол					
1.1		Журам батлах, журмын хавсралтад Өөрчлөлт оруулах тухай 2024.02.28 №83	Төрийн захиргааны байгууллагад тасралтгүй 5 жил ажилласан 2 албан хаагчид 11.2 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.	100	
2. Нийслэлийн Засаг даргын захирамж					
2.1		Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай 2024.01.23 А/91	Иргэдээс бичгээр 16, 11 төвөөр 2 нийт 18 өргөдөл ирүүлснийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, 16 өргөдлийн хариуг утсаар, 2 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлсэн. Шийдвэрлэгдээгүй буюу хугацаа хоцроосон өргөдөл байхгүй, өргөдлийн шийдвэрлэх дундаж хугацаа 10 хоног байна. Байгууллагынхаа мэдээ, мэдээллийн самбарт ажил олгогч иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг хүлээн авч байршуулан ажилладаг.	100	
Хэсгийн дундаж: хувь 100					

3. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал

3.1		Журам батлах тухай (Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авах, батлагаажуулах тухай) 2023.12.25 А/199	Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг 64 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 199 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу хүлээн авч баталгаажуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа хугацаа хоцроосон, мөн хуулийн хугацаанд өгөөгүй зэрэг ажил олгогч байхгүй байна.	100	
3.2		Журам батлах тухай (Улсын байцаагчийн) 2024.03.01 А/40	2024 онд шинээр улсын байцаагчийн шалгалт өгөх албан хаагч байхгүй бөгөөд нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын журамтай бүх албан хаагчид танилцсан.	100	
3.3		Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай 2024.03.12 А/53	Байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор шилэн дансны мэдээллийг 2 албан хаагч хариуцан томилогдон ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн ил тод байдлыг хангаж хуулинд заасан мэдээлбэл зохих сангийн 165, санхүүгийн 171, хүний нөөцтэй холбоотой 55 мэдээллүүдийг хугацаанд нь цахимаар байршуулсан, мэдээлээгүй болон хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй.	100	
3.4		Журам батлах тухай Итгэлцүүр хэрэглэх журам 2024.04.04 А/202	Шинээр 51 тэтгэвэр тогтоосноос шинэчлэн тогтоосон итгэлцүүрийн журмаар 26 тэтгэврийг тогтоон олгосон.	100	
3.5		Мэргэшлийн зэрэг олгох тухай 2024.04.18 А/80	Тус газрын улсын байцаагчин эрхтэй 1 зөвлөх зэрэгтэй алба хаагчид үндсэн цалингийн 20 хувийн, 2 албан хаагч тэргүүлэх зэрэгтэй үндсэн цалингийн 15 хувиар олгож байна.	100	

3.6		Журам өөрчлөлт оруулах тухай (мэргэшлийн зэргийн нэмэгдэлд өөрчлөлт оруулах) 2024.10.08 A/29	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг гурван албан хаагчид 5 хувиар нэмэгдүүлэн олгосон.	100	
3.7		Ажлын хээг байгуулах, удирдамж батлах тухай (УБ-ийн шалгалт авах тухай) 2024.10.17 A/37	Тус газраас 2024 онд улсын байцаагчийн шалгалт өгөх эрх үүссэн албан хаагч байхгүй байна.	100	
Хэсгийн дундаж: хувь100					
4. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					
4.1		Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2023.12.04 №10	Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох хэмжээг Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн төвтэй хамтран ажил олгогчын сургалтаар иргэд даатгуулагчдад сурталчлан мэдээ, мэдээллээр хангасан.	100	

4.2		Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай (Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж) 2023.12.04 №08	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулинд өөрчлөлт орж 2024 оноос мөрдөн ажиллаж байгаа бөгөөд нас барсан 21 тэтгэвэр авагчийн ар гэрт 42.0 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.	100	
4.3		Журам батлах тухай Нэрийн дансны үлдэгдлийг тооцох тухай 2024.03.05 №01	Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг албан хаагч нарт танилцуулсан.	100	
Хэсгийн дундаж: хувь100					
5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
5.1		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/02 2024.01.02	Нийгмийн даатгалын сангийн орлого 3.2 тэрбум төгрөг, сангийн 8.3 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж , зориулалтын дагуу зарцуулан, төсвийн сахилгыг ханган ажилласан.	100	
5.2		Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай А/03 2024.01.04	2024 онд 292.0 сая төгрөгийн үйл ажиллагааны санхүүжилт аван цалинд 199.9 сая төгрөг, НДШ-д 24.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 4.2 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад 11.2 сая төгрөг гэх мэт 11 төрлийн зардлыг Төсвийн тухай , Төрийн хэмнэлтийн тухай хууль, ЗГ-ын тогтоолын дагуу төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж, батлагдсан төсвийн зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэнэ гэж	100	
5.3		Журам шинэчлэн батлах тухай 2024.02.28 А/19	Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа маягтуудыг батлагдсан загварын дагуу ашиглаж бараа матераилын болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гарган тооцоо нийлэн ажиллаж байна. Дутагдсан маягт байхгүй байна. Жилийн эцсийн байдлаар Бланк А4 280 ш, А5 336 ш, Тушаал 108 ш	100	

5.4		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.03.18 А/35	Төсвийн хуваариар нийгмийн даатгалын зөвлөн туслах ажил үйлчилгээний зардалд 4.7 сая төгрөгийн өөрчлөлт орсныг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	100	
5.5		Үйл ажиллггааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай 2024.03.18 А/34	Үйл ажиллагааны төсөвт өөрчлөлт ороогүй бөгөөд өмнөх хуваарийн дагуу зарцуулж байна.	100	
5.6		Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай 2024.04.02 А/43	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн 8 код шинээр нэмж батлагдсан ба тайланг хүлээн авахдаа даатгуулагчийн төрлийн кодыг нягтлан шалгаж одоогоор буруу тайлагнасан төрлийн код засах зэрэг асуудал байхгүй байна.	100	
5.7		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.03.18 А/49	Нийгмийн даатгалын сангийн зарлагын төсвийн хуваарьт өөрчлөлт орсон бөгөөд ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа , зөвлөн туслах үйлчилгээний зардалд 4.7 сая төгрөг нэмэлтээр батлагдаж нийт сангийн зардал 8.3 тэрбум төгрөг батлагдсан.	100	
5.8		Үйл ажиллггааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай 2024.04.08 А/47	Үйл ажиллагааны төсөвт өөрчлөлт ороогүй бөгөөд өмнөх хуваарийн дагуу зарцуулж байна.	100	

5.9		Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай 2024.04.08 А/52	Тус газар нь А/52 дугаар тушаалаар 6 хүний бүтэцтэй батлагдсан ба албан хаагчдыг 2018 оны НДЕГ-ын даргын А/22 дугаар тушаалаар томилсон албан тушаалаас газрын даргын 2024.06.19 өдрийн Б/20 тоот тушаалаар шинэ бүтцийн албан тушаалд томилсон.	100	
5.10		Төлөвлөгөө батлах тухай(Шударга байдлын үнэлгээ) 2024.04.08 А/48	Төлөвлөгөөний дагуу шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулсан ба биелэлтийг хагас жилээр 2024.05.25-нд, жилийн эцсээр 2024.11.27-нд 83 тоот албан бичгээр ЗУГ-т гарган өгсөн.	100	
5.11		Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай (мэдээллийн ил тод байдал) 2024.02.08 А/20	Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн 169 сангийн 171 , хүний нөөцийн 55 мэдээллийг цахим системд байршуулсан ба байгууллагын вэб хуудсанд 10 заалтын 38 арга хэмжээг байршуулан НДЕГ-ын ДАМ Г-аас хяналт шалгалтыг хийж, хагас жилээр 57.8 хувьтай үнэлэгдсэн. Жилийн эцсээр хяналт шалгалт хийгдсэн бөгөөд эцсийн үнэлгээ гараагүй байна.	100	
5.12		Төлөвлөгөө батлах тухай(Шударга байдлын үнэлгээ) 2024.04.08 А/48	Оны эхний 140.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 43.2 сая төгрөгийг буюу 30.8 хувиар бууруулсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага үүсгэсэн 15 аж ахуйн нэгж байгууллагын 54934.8 мян төгрөгийн өр авлагад албан шаардлага хүргүүлж, 44055.8 мян төгрөг авлага барагдуулан, 16 байгууллагатай 73757.0 мян төгрөгийн өр авлагатай ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 31280.9 мян төгрөгийн авлага барагдуулан ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн өртэй Мөнх оргил цамхаг ХХК- 12,6 сая төгрөг, Авдрын гол овоо ХХК -6.3 сая, Амарсанаа степ 52.3 сая төгрөг, Иргэн Г.Эрдэнэбаяр 0.3 мянган төгрөг, нийт 71.5 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хэлтэст албадан гүйцэтгүүлэхээр хандсан. ШШГ хэлтэс хуулийн дагуу дээрх ажил олгогчдын данс хаах хөрөнгийг битүүмжлэн хурааж үнэ хаялцуулах дуудлага худалдаа зохион байгуулж шимтгэлийн авлага барагдуулахад албадан гүйцэтгэх дээрх ажил хийгдсэн байна.	100	

5.13		2024 оныг Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай 2024.04.24 А/61	Засаг даргын Нийгмийн бодлогын хөгжлийн орлогчоор ахлуулсан Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс албадын мэргэжилтнүүдийн хамт 2024 оны 4 дүгээр сарын 9,10-нд, 11 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд дүүргийн шугам замын өртөө болон малчин өрхөд явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 4 удаа үйлчилж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдээ, мэдээлэл өгч ажилласан. Явуулын үйлчилгээнд нийт 30 өрхийн 97 иргэн хамрагдсан бөгөөд 9 иргэний тэтгэвэр тогтоолтын баримт бичгийг шалгаж, 5 өрхөд малчны сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 5 төрлийн 160 гарын авлага тараан ажиллалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан тус газар нь 2024 оны 9 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд дүүргээс алслагдсан төмөр замын байгууллага болон малчин өрхүүдэд 3 байцаагч, мэргэжилтнүүд нийгмийн даатгалын үйлчилгээг ойртуулан ажлын байранд болон гэрт нь хүргэн ажилласан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажил олгогч-67, албан журмын даатгуулагч-1035, СДД-144, хүүхдээ асарч буй СДД-1, малчин СДД-3, ХБИ-15 хамруулах төлөвлөгөөтэй байна. Үүнээс: Ажил олгогч-64, АЖД-939, СДД-120, Малчин СДД-4 ХБСДД-.1. хамруулсан байна.	100	
------	--	---	---	-----	--

5.14		Болзолт уралдаан зарлах тухай 2024.05.17 А/79	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа шинээр байгуулагдсан Багахангай од арвижих ХХК, Дезель план ХХК, Багахангай сүү ХХК, Буянт хангайн булаг ХХК, Мөнх -эвлэрэл ХХК зэрэг таван байгууллага хамруулж нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэж авч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээж авч тооцоог тухай бүр хийж байна. Шинээр хамруулсан байгууллагын 7 даатгуулагч нэмэгдүүлэн ажиллаа. Дүүргийн Засаг даргын тамгийн газар болон дэргэдэх хэлтэс албадтай хамртан дүүргийн дүүргээс алслагдсан өртөө, Хоолт, 86, Чулуут, Ханай, Цагаан хяр, 12дугаар зөрлөг, Мааньт, агуйт зөрлөгийн болон хөдөөний малчин айл өрхөөр явж нийгмийн даатгалын хуулийг сурталчилан зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаа. 45 өрхийн 63 даатгуулагчтай уулзалт хийв. Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч орд ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, БЗАҮАнги, Төмөр замын 12-р хэсэг, 44-р цэцэрлэг зэрэг 6 аж ахуй нэгж байгууллага 163 даатгуулагчдад нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэн ажилласан. Нийслэлийн ерөнхий боловсролын “Хангай” сургуулийн төгсөх ангийн 63 суралцагчдад “Сайн дурын даатгал” сэдэвт сургалтыг зохион байгуулж мэдээлэл өгч ажиллалаа.	100	
5.15		Ажил зохион байгуулах тухай (Хүсэлт илгээсэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч шийдэвэрлэж, ажил үүргийг хуваарилан ажиллах тухай) 2024.08.05 А/137	Нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар тэтгэвэр-47, ажилгүйдлийн тэтгэмж-45, ЖА тэтгэмж-73-, ХЧТА-ын тэтгэмж-135, ХЧТА-ын хугацааны сунгалт-59, даатгуулагч тус тус хүсэлт гаргасныг 306 хүсэлтийг шийдвэрлэж 6 шийдвэрлэгдээгүй байна. Хуулийн хугацаандаа шийдвэрлэхээр байна.	100	
5.16		Маягтын загвар батлах тухай 2024.05.21 А/83	Хяналт шалгалтын байцаагч нар зөрчил шалган шийдвэрлэх, мөн улсын байцаагчийн акт, албан шаардлагыг шинээр батлагдсан маягтын дагуу үйл ажиллагаандаа хэрэглэж байна. 15 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн байна.	100	

5.17		Аудитын акт, албан шаардлага зөвлөмж хэрэгжүүлэх тухай 2024.05.31 А/94	2023 оны аудитын дүгнэлтээр зөрчилгүй, 2 албан шаардлага, 3 зөвлөмжтэй дүгнэгдсэн. Аудитын зөвлөмж, албан шаардлагын дагуу засаж сайжруулах хийх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг 2024.06.30-нд гарган өгсөн.	100	
5.18		Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн сарын хуваарийг өөрчлөн батлах тухай 2024.06.11 А/100	Батлагдсан төсвийг Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэгдэж буй хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмжийн зардлаас 12.0 сая төгрөгийг хэмнэн төсвийн хуваарьт өөрчлөлт орсон. /246.7-с 234.7 буурсан/	100	
5.19		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.06.14 А/106	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарьт улсын төсвөөс хариуцан төлөх малчин, туслах малчны шимтгэлийн орлого 10.6 сая төгрөгөөр нэмэгдэж нийт нийгмийн даатгалын сангийн орлого 3.2 тэрбум төгрөг батлагдсан.	100	
5.20		Журам батлах тухай. (Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн буцаан олгох журам) 2024.06.18 А/107	Журамтай танилцсан бөгөөд 2024 оны нийгмийн даатгалын илүү төлсөн шимтгэлийн нэрс 2025 оны эхний хагас жилд холбогдох газраас ирүүлэхэд буцаан олголтыг хийхээр байна.	100	
5.21		Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн сарын хуваарийг өөрчлөн батлах тухай 2024.07.16 А/129	Үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зориулалтын дагуу 12.1 сая төгрөгийн зардлыг хэмнэн дээд шатны байгууллагад шилжүүлэн ажилласан.	100	
5.22		Унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024.07.29 А/135	Газрын даргын 2024.09.19-ний өдрийн Б/22 дугаар тушаалаар 6 албан хаагчдад 2024 оны 08 дугаар сарын 15-наас хэлэн унаа хоолны хөнгөлөлтийг нэг өдрийн 25000 төгрөгөөр тооцон олгож эхэлсэн.	100	

5.23		Ажил зохион байгуулах тухай (Шинэ сигос системийн бүртгэлийн тухай) 2024.08.05 А/137	Нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар тэтгэвэр-47 ажилгүйдлийн тэтгэмж-45, ЖА тэтгэмж-73-, ХЧТА-ын тэтгэмж-135, ХЧТА-ын хугацааны сунгалт-59, даатгуулагч тус тус хүсэлт гаргасныг 306 хүсэлтийг шийдвэрлэж 6 шийдвэрлэгдээгүй байна. Хуулийн хугацаандаа шийдвэрлэхээр байна.. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг биеэр хүлээн авч шийдвэрлэж байна. Цахимаар хүлээн авах боломжтой боловч интернэт орчин ашиглах боломжгүй гэх мэт даатгуулагчийн хүсэлтийг биеэр хүлээн авч байцаагч цахим системд оруулан бүртгэн авч шийдвэрлэж байна.	100	
5.24		Төлөвлөгөө батлах тухай (Сахилга хариуцлагыг дээшлүүлэх) 2024.08.05 А/138	Сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажлын биелэлтийг 14 хоног тутам НДЕГ-ын ЗУГ-ын мэргэжилтэнд гарган холбогдох замд байршуулж өгсөн.	100	
5.25		Ажлын цаг ашиглалт, бүтээмж хариуцлагыг сайжруулах тухай. 2024.08.14 А/139	Ажлын цаг ашиглалтад удирдлага болон Ахлах мэргэжилтний зүгээс хяналт тавьж, тайлант хугацаанд ёс зүйн болон авилга ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. Байгууллагын ёс зүйн дэд хороо 2 удаа хуралдсан бөгөөд ёс зөрчил хянан хэлэлцээгүй байна.	100	
5.26		Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай 2024.09.12 А/153	“Унаа , хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/135 тоот тушаалаар унаа, хоолны зардлын нөхөх төлбөрийн хэмжээг 4.2 сая төгрөгөөр төсөв нэмэгдсэн.	100	
5.27		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 2024.09.12 А/154	Нийгмийн даатгалын сангийн орлого 3.4 тэрбум төгрөг, сангийн зарлага 8.7 сая төгрөг болон нэмэгдсэн.	100	

5.28		Аян зохион байгуулах тухай (НДШ-ийн өр барагдуулах талаар) 2024.09.26 А/162	Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага үүсгэсэн 15 аж ахуйн нэгж байгууллагын 54934,8.0 мян төгрөгийн өр авлагад албан шаардлага хүргүүлж, 44 055,8 мян төгрөг авлага барагдуулан, 16 байгууллагатай 73757.0 мян төгрөгийн өр авлагатай ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 31280.9 мян төгрөгийн авлага барагдуулан ажилласан. Өр авлага үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичгийн бүрдүүлбэрийг ханган 2 аж ахуйн нэгж Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллаж шүүхэд шилжүүлэн 2830,0 мян төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагад 2465,3 мян төгрөгийн алданги нийт 5295,3 мян төгрөгийн өр авлагыг албан гүйцэтгүүлэхээр шилжүүлэн ажиллалаа.	100	
5.29		Маягтын загвар батлах тухай (Улсын байцаагчийн хэрэглэх) 2024.10.03 А/169	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 15 ажил олгогчид авлага барагдуулах талаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.	100	
5.30		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.10.22 А/179	Өөрчлөлт ороогүй		
5.31		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.11.12 А/202	Өөрчлөлт ороогүй		

5.32		Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2024.11.25 А/201	Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх болон багаж сэлбэг хэрэгслийн зардал 10.0 сая төгрөг, урсгал зардалд 11.5 сая төгрөг тус тус нэмэгдэж нийт батлагдсан төсөв 292.0 сая төгрөг.	100	
5.33		Сургалт зохион байгуулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах тухай 2024.11.29 А/217	ҮОМШӨ-ний 3 сая төгрөгийн санхүүжилт орсон бөгөөд байгууллагын пэйж хуудсан дээр сургалт зохион байгуулах зарыг байршуулсан.	100	
Нийт дундаж хувь 100					

ХЯНАЖ ТАНИЛЦСАН:
ДАРГА

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН
ХҮНИЙН НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТӨН



Б.БАЯРТУЯА

А.МӨНХЦЭЦЭГ